



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Д.Батбаатарын танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын Либерал Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Отгонбатаас “Улсын дээд шүүхийн 02/208 дугаартай албан бичигт заасан зөрчлийг арилгахаар намын Бүгд хурал дахин хуралдаж, намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан...” гэх өргөдлийг 72 хуудас баримт бичиг, 1 ширхэг флашны хамт 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба сонсох ажиллагааны явцад нэмэлтээр 81 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Монгол Либерал Ардчилсан намын шинэчилсэн дүрмийг бүртгэж шийдвэрлэв.

Нэг. Өргөдөлд хавсарган ирүүлсэн Монголын Либерал Ардчилсан намын Ээлжит бус Их чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 005, 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Бүгд хурлын 004 дүгээр тогтоолоор намын шинэчилсэн дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэхийг намын Ерөнхий нарийн бичгийн даргад даалгасан, сонсох ажиллагааны явцад тус намын Хэрэг эрхлэх газрын даргаас “намын дарга Д.Пүрэвдаваа нь Үндэсний

эвслээс Улсын Их Хуралд нэр дэвшиж сонгогдон, намаасаа татгалзсан"-ыг тайлбарласан, намын дүрмийн 3.10-т "намын Ерөнхий нарийн бичгийн дарга нь намын даргын эзгүйд түүний үүргийг орлон гүйцэтгэх"-ээр заасан зэргээс үзэхэд өргөдөл гаргагч Д.Отгонбат тухайн намыг төлөөлөх эрхтэй этгээд байна.

Хоёр. Монголын Либерал Ардчилсан намын дүрэм (2023 он)-ийн 3.7.6-д "Аймаг, нийслэлийн Бага чуулган нь АШБ-аас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ", 3.7.6.3-т "Бага чуулган нь Их чуулганд төлөөлөгч томилно", 3.7.8.7-д "Намын Их чуулганыг чуулах тов, төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг намын Бүгд хурал батлан гаргана" гэж тус тус заасан.

Өмнө нь, Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02/208 дугаар албан бичгээр "Монголын Либерал Ардчилсан намын Ээлжит бус 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Их чуулганы намын дүрмийг шинэчлэн батлах үйл ажиллагаанд оролцсон зарим гишүүдийн анкет байхгүй, тухайн намын гишүүн мөн эсэх нь тодорхойгүй, намын дүрэмд тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулж, хуульд заасан асуудлыг дүрэмд өөрөөр зохицуулсан нь Улс төрийн намын тухай хуульд нийцээгүй" болон бусад алдаа зөрчлийн улмаас шууд бүртгэх боломжгүй, дурдсан асуудлуудыг тодруулах шаардлагатайг мэдэгдсэн.

Тус намаас "... Манай нам өмнөх жилүүдэд идэвхтэй, тасралтгүй үйл ажиллагаа явуулаагүй бодит нөхцөл байдлын улмаас орон нутгийн анхан шатны байгууллагуудыг бүрэн байгуулж, аймаг, нийслэлийн төлөөллийн тогтолцоог бүрдүүлж амжаагүй байсан. 2023 онд бүртгэгдсэн намын дүрмийн зохицуулалтаар намын төлөөллийн төв байгууллага нь намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр заасан. Иймд манай нам дүрэмд өөрчлөлт оруулах болон намын дотоод зохион байгуулалттай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр Улсын дээд шүүхэд баримт бичгээ хүргүүлсэн" гэх тайлбарыг, 11 гишүүний гарын үсэг бүхий анкетын хамт ирүүлжээ.

Гурав. Мөн Монголын Либерал Ардчилсан намын Бүгд хурал 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж, намын шинэчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталсан, Улсын дээд шүүхийн Бүртгэлийн албаны сонсох ажиллагааны явцад зарим тодорхой бус асуудлыг тодруулж, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр дахин хуралдаж, 005 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцсэн байна.

3.1.Намын дүрэм (2023 он)-ийн 3.7.9.9-д "Бүгд хурлыг шаардлагатай үед Ерөнхий зөвлөл зарлан хуралдуулна. Бүгд хурлын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь шаардсан нөхцөлд Бүгд хурлыг хуралдуулж болно" заажээ.

Өргөдөл, түүнд холбогдох баримтуудаас үзэхэд, тухайн намын Ерөнхий зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 001 дүгээр тогтоолоор Бүгд хурлыг 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр, мөн зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 002 дугаар тогтоолоор Бүгд хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр тус тус хуралдуулахаар шийдвэрлэсэн бөгөөд хурлын товыг 65 гишүүнд мэдэгдсэнээс 2026 оны 03 дугаар сарын 14-ны өдөр 38 гишүүн, 04 дүгээр сарын

11-ний өдөр 44 гишүүн тус тус оролцсон нь тухайн хуралд оролцох эрхтэй төлөөллийн төв байгууллагын гишүүд мөн эсэхийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэрэг, өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтаас шалгахад, Бүгд хурлын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 004, 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 004 дүгээр тогтоолоор тус тус дээрх гишүүдийн бүрэн эрхийг баталсан, процессын зөрчилгүй байна.

3.2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж, намын дүрэм (2023 он)-ийн 3.1-д “Нам үйл ажиллагаандаа зөвшлийн ардчилсан зарчмыг баримтална. Аливаа асуудлаар ердийн олонх (50+1%)-ын дэмжлэг авсан тохиолдолд зөвшилцөлд хүрсэн гэж үзнэ”, 3.7.9.7-д “Бүгд хурал шаардлагатай гэж үзвэл намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно”, 3.7.9.12-т “Намын дүрмээр зохицуулах намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг намын эрх бүхий байгууллага буюу Бүгд хурал шийдвэрлэнэ” гэж тус тус заасан.

Намын Ээлжит бус 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Их чуулганы 005 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэм нь нийт 510 буюу 7 бүлэг, 73 зүйл, 274 хэсэг, 163 заалттайгаас Бүгд хурлын 2026 оны 03 дугаар сарын 14, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаас нийт 28 зүйл, 87 хэсэг, 55 заалт буюу дүрмийн 33.3 хувьд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хуулийн 17.4-т заасантай нийцжээ.

Бүгд хурлын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанд 38 гишүүн, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд 44 гишүүн оролцсоноос тус бүр 100 хувийн саналаар дээрх намын шинэчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь Тооллогын комиссын 2026 оны 03 дугаар сарын 14, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоол, хуралдааны тэмдэглэл болон өргөдөлд хавсарган ирүүлсэн бусад баримтуудаар тогтоогдож байна.

Дөрөв. Монголын Либерал Ардчилсан намын дүрэм нь Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэг. Намын гишүүнчлэл, Гуравдугаар бүлэг. Намын удирдлага, зохион байгуулалт, Дөрөвдүгээр бүлэг. Намын салбар, хороо, дэргэдэх байгууллага, зөвлөл, Тавдугаар бүлэг. Намын дотоод сонгуулийн зарчим болон төрийн улс төрийн удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, Зургаадугаар бүлэг. Намын санхүү, эд хөрөнгө, тайлан, хяналт, Долдугаар бүлэг. Намыг өөрчлөн байгуулах, дүрэмд өөрчлөлт оруулах гэсэн нийт долоон бүлгээс бүрдсэн байх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана”, 15.2.1-15.2.10-т заасан намын дүрэмд тавигдах шаардлагад нийцсэн байна.

Тодруулбал, тус намын 2026 оны 03 дугаар сарын 14, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Бүгд хурлаар Улсын дээд шүүхийн 2026 оны 02/208 дугаартай албан бичигт дурдсан “намын дүрэмд намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг тусгаагүй, сахилгын шийтгэл ногдуулах

хөөн хэлэлцэх болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа, үр дагаврыг зохицуулаагүй, салбар болон бүтцийн бусад нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам болон төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар бүтцийн нэгжид хуваарилахтай холбоотой асуудал, хууль бус хандивтай холбоотой алдаа зөрчлийг орон нутгийн салбар нэгж гаргасан тохиолдолд хэрхэн зохицуулахыг тусгаагүй, орхигдуулсан, мөн техникийн шинжтэй” алдаа зөрчлийг зассан байна.

Иймд, Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын Ээлжит бус Их чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 005, Бүгд хурлын 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 004, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 005 дугаар тогтоолоор тус тус баталсан намын шинэчилсэн дүрэм нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг бүрэн тусгасан тул бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Монголын Либерал Ардчилсан нам (МоЛАН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР